

“КЛОВЕР ББСБ” ХХК-ИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. КОМПАНИЙ ТУХАЙ

Алсын хараа - Кловер ББСБ нь сайн сайхныг санхүүжүүлж, шинэ шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээгээр нийгэм эдийн засагт бодитой хувь нэмэр оруулан салбартаа манлайлан ажиллана.

Эрхэм зорилго - Бид санхүүгийн цогц үйлчилгээг харилцагчиддаа мэргэжлийн өндөр түвшинд шинэлэг үйлчилгээг хүргэдэг хамгийн сайн харилцаатай эрсдэлгүй банк бус санхүүгийн байгууллага байж эх орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулна.

Үнэт зүйлс

- Бид харилцагч бүрийг хүндэтгэнэ
- Орчин үеийн бүтээгдэхүүн үйлчилгээ
- Чадварлаг мэргэшсэн боловсон хүчин
- Харилцан итгэлцэл

2. КОМПАНИЙ ЗАСАГЛАЛ

Кловер ББСБ ХХК-нь Монгол улсад бүртгэлтэй ,хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр байгуулагдсан ББСБ бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжоос гадна банкнаас бусад зохицуулалттай салбарын зохицуулагч Санхүүгийн зохицуулагч хороо (СЗХ)-оос баталсан Компаний засаглалын кодексийг дагаж мөрдөх үүрэгтэй.

Санхүүгийн зохицуулах хороо 2023 онд ББСБайгууллагуудад дахин компаний засаглалын зайны үнэлгээг хийж,хэрэгжилтийн үнэлгээний тайланг гаргав.

Кловер ББСБ ХХК-ны Санхүүгийн зохицуулах хорооны компаний засаглалын кодекс хэрэгжилтийн үнэлгээ **83.3** авсан.

2.1. Төлөөлөн удирдах зөвлөл

2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

ТУЗ-нь Хувьцаа эзэмшигчдээс нэр дэвшүүлсэн 3 гишүүн 1 хараат бус гишүүн,нарийн бичгийн даргаас бүрдсэн дараах бүрэлдхүүнтэй байна.

ТУЗ-ийн дарга Д.Шинэбаяр
ТУЗ-ийн гишүүн Б.Алтанцэцэг
ТУЗ-ийн гишүүн Д.Итгэлмаа
ТУЗ-ийн гишүүн А.Болормаа

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Л.Одмаа

Компаний ТУЗ-ийн гишүүдийн бүтцэд өөрчлөлт оров.

Компаний ТУЗ болон түүний дагалдах журам шинээр боловсруулав.


2.2. Хувьцаа эзэмшигчид

1. Дангаасүрэн Шинэбаяр


2. Бямбасүрэн Алтанцэцэг

3. БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. Зээлийн үйл ажиллагаа



/мянган төгрөгөөр/




/мянган төгрөгөөр/

3.2. Санхүүгийн голлох үзүүлэлтүүд



/мянган төгрөгөөр/



/мянган төгрөгөөр/

3.3. 2023 оны онцлох үйл явдал

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд	
1	Компаний дүрмийн санг 4.0 тэрбум төгрөгт хүргэв.
2	2023 оны тайлант хугацаанд “Компанийн касаглалын кодекс”-ыг хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд “Дотоод аудитын бодлого”, “Дотоод хяналтын бодлого”-ыг тус тус боловсруулан компанийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг тасралтгүй хэрэгжүүлэн ажиллав. Дотоод аудитын хүрээнд 2023 оны жилийн эцсийн тайланг хянан баталгаажуулах аудитын компанийг сонгов.
3	Хувьцаа эзэмшигчдэд компаний ноогдол ашиг 729,262,000.00 төгрөг хуваарилав
4	Монгол улсад 2023 онд 250.0 сая төгрөг,2024 оны эхний хагас жилд 289.0 сая төгрөгийн татвар нийтдээ 539.0 төгрөгийн татвар төлсөн
5	МХАҮТ-ийн Платинум гишүүн боллоо
6	Жилийн эцсийн санхүүгийн тайланг Акпар аудит ХХК-д хийлгэсэн
7	Хөндлөнгийн хяналтын байгууллагаар тайлант хугацааны санхүүгийн байдалд дүгнэлт гаргуулан, санхүүгийн ил тод байдлын хүрээнд мэдээллийг олон нийтэд болон Санхүүгийн зохицуулах хороо хүргэн, мэдээллийн ио тод байдлыг ханган ажиллав.
8	Байгаль орчинд ээлтэй, ногоон зээлийн талаар дотооддоо албан хаагчдад зориулсан танин мэдэхүйн сургалт явуулав.
9	Машинаа унаад зээлээ ав бүтээгдхүүнийг нэвтрүүлэв
10	Грейп сити Поларис санхүүгийн систем нэвтрүүлэв
11	Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 434 дүгээр тогтоолоор “Итгэлцлийн үйлчилгээний журам” шинэчлэн баталсантай холбоотойгоор итгэлцлийн үйлчилгээний журам шинээр боловсруулав.
12	Санхүүгийн зохицуулах хорооны дарга,Сангийн сайдын 2023 оны А/226/528 дугаар хамтарсан тушаалаар “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам ‘-ыг СТОУС-д нийцүүлэн шинэчлэн баталсантай холбоотойгоор манай компани мөрдөн ажиллаж байна.
13	Монголын ББСБ холбооноос зохион байгуулсан сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнд эдийн засагч С.Сансар амжилттай оролцлоо.
14	Компаний хөрөнгөнд “Хөрөнгийн үнэлгээний төв”ХХК-аар дахин үнэлгээ хийлгэсэн
Нийгмийн хариуцлагын хүрээнд	
15	Зуданд нэрвэгдсэн малчдад 500.000 төгрөгийн хандив өгсөн.
16	Монголын ББСБ холбооноос зохион байгуулдаг цус хандивлах аянд идэвхтэй оролцсон.
17	МББСБ-н цэцэрлэгт хүрээлэнд мод тарих үйл ажиллагаанд идэвхитэй оролцож 1,2 сая төгрөгийн мод тарьсан.

4. ЭРСДЛИЙН УДИРДЛАГА

Компаний үнэ цэнийг хамгаалах зорилгоор эрсдэлийн удирдлагын багийг бүрдүүлэн,ирээдүйд учирч болох эрсдэлийн төрлийг тодорхойлж хянаж удирдан ажиллаж байна.Компани нь эрсдэлийн удирдлагын засаглалаа 2023 оноос ТУЗ-ийн дэргэд “Эрсдэлийн удирдлагын хороо”г шинээр байгуулан ажиллаж байна.Эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь эрсдэлийг хариуцах,хянах удирдах ,засаглалыг бүрдүүлэх чиг үүргүүдийг хуваарилан ажилладаг.Компаний стратеги төлөвлөгөөнд нөлөөлөх гадаад дотоод орчны эрсдэл болон боломжийг гүйцэтгэх удирдлагын багаар жил бүр шинэчлэн тодорхойлж авах арга хэмжээг төлөвлөдөг хэрэгжилтийг хянах замаар ханган ажиллаж байна.

Зохицуулагч байгууллагаас тавьдаг зохистой харьцааны шалгуур болох өөрийн хөрөнгийн хүрэлцээ,төлбөр түргэн гүйцэтгэх чадвар,актив хөрөнгийн төвлөрөл,бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө болон үндсэн хөрөнөгийн үзүүлэлтүүдийг хангаж ажиллалаа.

Компани нь зээлийн эрсдэлийг удирдах журмаар зээлдэгч,зээлийн бүтээгдхүүн ,барьцаа хөрөнгийн эрсдэлийг тодорхойлон зээлийн оночтой багц бүрдүүлэх ,зээлийн эрсдэлийн дохиог эрт илрүүлэх,зээлдэгчийг таних ,барьцаа хөрөнгийн үнэлгээг автоматжуулж хүнээс хамаарсан эрсдэлийг бууруулах зарчим баримтлан ажиллаж байна.

МУТСТ хууль болон СЗХ-оос гаргасан МУТСТ үйл ажиллагаа журмын дагуу журам боловсруулан ажиллаж байна.

ББСБ-уудын салбар өргөжихийн хэрээр байгууллагууд технологийн дэвшил ,мэдээлэл солилцох, боловсруулах хурдаар өрсөлдөж байгаа тул Мэдээллийн технологи,аюулгүй байдлын эрсдэл шууд нэмэгдэж байна.Иймд байгууллагын үнэ цэнэтэй мэдээллийн нууцтай ,хүртээмжтэй,бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллахыг зорин ажиллаж байна.

ТУЗ-ийн үйл ажиллагаа болон гишүүдийн ажлыг үнэлэх үнэлгээний журам мөн компанийн цалин, урамшууллын зарчим бодлогыг боловсруулан, баталгаажуулж эрх бүхий байгууллагад хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллав.

Компанид ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх бодлогын баримт бичгийг боловсруулан, баталгаажуулж мөрдлөг болгон ажиллаж байгаа бөгөөд мөн оролцогч талуудтай жигд, тогтвортой хамтран ажиллах зарчмыг баримтлан ажиллаж байна.

Компани нь байгаль орчин,олон нийтэд сөрөг нөлөө үзүүлэх үйл ажиллагаа эрхэлдэггүй .

Нийгмийн хариуцлагын хүрээнд олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаанд тодорхой хэмжээний төсөв гарган оролцож байна.

Хөдөлмөр эрүүл мэнд аюулгүй байдлын хувьд ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулж,ажлын байрны хэвийн нөхцөлөөр бүрэн хангаж ,эрсдэлээс сэргийлдэг.

5. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

Бид Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн ханган ажилласан.

2022, 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн гол үзүүлэлтүүд дараах байдалтай байна. Үүнд:

5.1. Аудитын дүгнэлт



**“КЛОВЕР” БАНК БУС
САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН
УДИРДЛАГАД**

**Хараат бус аудиторын
тайлан**

Бид Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн холбогдох заалтуудыг үндэслэн “Кловер” ББСБ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон Санхүүгийн байдлын тайлан (баланс), Орлого үр дүнгийн тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан буюу тайлангийн тодруулгуудаас бүрдсэн жилийн эцсийн Санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар “Кловер” ББСБ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн тайлангууд нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС), Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн. АОУС-д заасан аудиторын хүлээх үүрэг, хариуцлагыг “Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг, хариуцлага” гэсэн хэсэгт тусгаж харуулав. Аудитын ажилд хамааралтай хараат бус байдлын болон ёс зүйн шаардлагуудыг бүрэн биелүүлж ажилласан. Бидний олж авсан баримт нотолгоонууд дээрх дүгнэлтийг гаргахад хангалттай, тохиромжтой гэж үзэж байна.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Санхүүгийн тайлангаа СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан заавар журмын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох стандарт, хуульд нийцүүлэн боловсруулан, тогтмол мөрдөж ажиллах нь тухайн байгууллагын удирдлагын үүрэг болно.

Мөн түүнчлэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, хөрөнгийг янз бүрийн зальт ажиллагаанд өртүүлэхгүй байхаар дотоод хяналтын системийг бий болгох, байгууллагын үйл ажиллагааны болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурь, зарчмыг хангаж ажиллах нь байгууллагын удирдлагын хариуцлага юм.



Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг, хариуцлага

Аудиторын гол зорилго нь үйлчлүүлэгчийн санхүүгийн тайлангууд нь алдаа эсвэл залилангийн улмаас материаллаг буруу илэрхийллээс ангид эсэхэд дүгнэлт өгөхөд оршино. Тодорхой дүгнэлтэд хүрэхийн тулд АОУС-д нийцүүлэн боловсруулсан горимын дагуу шалгалт хийж, хангалттай, тохиромжтой баримт нотолгоо цуглуулах нь аудиторын үүрэг юм.

Аудитын горимуудыг батлагдсан төлөвлөгөөний дагуу аудитор өөрийн шийдлээр сонгох ба ирүүлсэн алдаа, зөрчил нь материаллаг буюу байгууллагын удирдлага болон хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх эсэхэд дүн шинжилгээ хийж, түүнд тохирсон дүгнэлт өгнө.

Аудитын шалгалтаар байнга алдаа зөрчил илрэх ёстой гэсэн ойлголт байж болохгүй бөгөөд бидний илрүүлсэн алдаа, зөрчил материаллаг бус бол түүнийг арилгуулах талаар тодорхой зөвлөгөө өгч ажиллана.

Цаасан болон цахим хэлбэрээр бэлтгэсэн аудитын ажлын баримтууд нь тус компанийн өмч бөгөөд аудиторын тайлан, зөвлөмжийн хамт 10 жил хадгална.



2024-01-29

5.2. Аудитлагдсан санхүү байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

БАЛАНСЫН ЗҮЙЛ	2022 он	2023 он
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	262,485.46	278,212.88
Богино хугацаат хөрөнгө оруулалт		
Зээл	5,290,165.12	5,213,340.63
Авлага	398,255.56	595,212.50
Бусад хөрөнгө		
Эргэлтийн хөрөнгийн дүн	5,950,906.14	6,086,766.01
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	692,292.82	692,292.82
Хуримтлагдсан элэгдэл	(110,359.27)	(141,635.83)
Биет бус хөрөнгө		
Хуримтлагдсан элэгдэл		
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	581,933.55	550,656.99
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,532,839.69	6,637,423.00
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр	500,000.00	-
Бусад эх үүсвэр	1,220,000.00	1,650,000.00
Бусад өр төлбөр	74,811.02	69,021.84
Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,794,811.02	1,719,021.84
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат өр төлбөр	-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
Өр төлбөрийн нийт дүн	1,794,811.02	1,719,021.84
Өөрийн хөрөнгө		
Энгийн хувьцаа	3,027,000.00	3,027,000.00
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
Хуримтлагдсан ашиг /алдагдал/	1,711,028.67	1,891,401.16
Нөөцийн сан		
Эзэмшигчдийн өмчийн дүн	4,738,028.67	4,918,401.16
ӨР ТӨЛБӨР, ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	6,532,839.69	6,637,423.00

5.3. Аудитлагдсан орлогын дэлгэрэнгүй тайлан

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2022 он	2023 он
Зээлийн хүүгийн орлого	2,168,701.92	1,656,875.14
Хүүгийн зардал	102,803.42	66,528.77
Цэвэр хүүгийн орлого	2,065,898.50	1,590,346.37
Хүүгийн бус орлого	69.36	2.86
Хүүгийн бус зардал	913,640.09	655,625.47
Цэвэр хүүгийн бус орлого	(913,570.73)	(655,622.61)
Болзошгүй эрсдлийн сангийн зардал	2,367.76	-
Үндсэн үйл ажиллагааны ашиг/алдагдал/	1,149,960.01	934,723.76
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	112,367.76	
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	2,000.00	27,500.00
Ердийн үйл ажиллагааны ашиг /алдагдал/	1,260,327.77	907,223.76
Ердийн бус орлого	-	-
Ердийн бус зардал	-	-
Татварын төлөхийн өмнөх цэвэр орлого	1,260,327.77	907,223.76
Орлогын татварын зардал	126,264.78	93,600.38
Татварын дараах цэвэр ашиг	1,134,062.99	813,623.38

5.4. Аудитлагдсан өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Хувьцаат капитал	Хуримтлагдсан ашиг/алдагдал/	Нийт дүн
2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	3,027,000.00	1,711,028.66	4,738,028.66
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга			-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз			-
Өмчид гарсан өөрчлөлт			-
Ногдол ашиг		(633,250.89)	(633,250.89)
Дахин үнэлгээний нэмэгдэл			-
Тайлант оны ашиг /алдагдал/		813,623.39	813,623.39
2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	3,027,000.00	1,891,401.16	4,918,401.16

5.5.

5.5. Зохистой харьцааны тайлан

Д/д	ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ	БАЙВАЛ ЗОХИХ	ТАЙЛАН ГААР	ХАНГАСАН ЭСЭХ
------------	--------------------------	---------------------	--------------------	----------------------

А. ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ				
1	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-аас доошгүй	69.1%	Хангасан
2	Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-аас доошгүй	69.1%	Хангасан
3	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	10%-аас доошгүй	74.1%	Хангасан
Б. ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА				
4	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-аас дээш	16.2%	Хангасан
В. АКТИВ ХӨРӨНГИЙН ТӨВЛӨРЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ				
5	Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+илүү - дутуу)	48,995.3	48,995.3	(0.0)
6	Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	30%-аас хэтрэхгүй	8.1%	Хангасан
8	Ббсб-ын хувьцаа эзэмшигч, туз, гүйцэтгэх захирал ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцаа	25%-аас хэтрэхгүй	2.8%	Хангасан
7	Ббсб-ын хувьцаа эзэмшигч, туз, гүйцэтгэх захирал ажилтан, холбогдох нэг этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	10%-аас хэтрэхгүй	1.8%	Хангасан
Д. БУСДААС ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД				
16	Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	80%-аас хэтрэхгүй	33.5%	Хангасан
Е. ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ				
17	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	15%-аас хэтрэхгүй	8.3%	Хангасан
Ж. ӨГӨӨЖ				
19	Хөрөнгө /актив/-ийн өгөөж			12.4%
20	Өөрийн хөрөнгийн өгөөж			16.9%

КЛОВЕР ББСБ ХХК

